



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 156

Жаргалант

“Иргэдийн амьжиргааг дэмжиж, ажлын байрыг  
нэмэгдүүлэх жил” болгон зарлаж,  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 17 тоот тогтоолыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. 2020 оныг сумын хэмжээнд “Иргэдийн амьжиргааг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх жил” болгон зарласугай.
2. Зарласан жилийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
3. Зарласан жилийн зорилт, арга хэмжээ, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Бямбадалай/-д үүрэг болгосугай.
4. Зарласан жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд бүтээлч санаачилга, бодитой үр дүн гаргаж ажиллахыг сумын нийт аж ахуйн нэгж байгууллагуудад уриалсугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн боловсруулж, сумын Засаг даргын зөвлөлд хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч /Ж.Хүрэлбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ОТГОНДАЛАЙ